

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-11</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>12-35</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны үйл ажиллагааны тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/</i>	<i>12-26</i>
<i>2. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>26-28</i>
<i>3. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>28-35</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 15 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Т.Аубакир, Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан;  
Эмнэлгийн чөлөөтэй: П.Анужсин, Ц.Мөнхцэцэг.

**Нэг.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны үйл ажиллагааны тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлагын зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан, бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан, бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Цацрал, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Г.Мөнхгэрэл, Боловсролын зээлийн сангийн дарга Д.Гарди, Боловсролын зээлийн сангийн нягтлан бодогч Ц.Тамир, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Энх-Амгалан, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Бямбасүрэн, Төсвийн ерөнхий нягтлан бодогч Г.Эрдэнэсүрэн, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Баттулга, Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалт,

үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од нар байлцав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ч.Ундрэм, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир, мөн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Боловсролын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Шинжлэх Ухаан, Технологийн их сургуулийн захирал Т.Намнан, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Дамдинням танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.*

**Г.Мөнхцэцэг:** 1.Төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дэх заалтын “зэрэг” гэсний дараа “цол” гэж нэмж, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх харьяа нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

**Г.Мөнхцэцэг:** 1.Төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дэх заалтын “зэрэг” гэсний дараа “цол” гэж нэмж, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх харьяа нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир, мөн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Боловсролын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Шинжлэх Ухаан, Технологийн их сургуулийн захирал Т.Намнан, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Г.Дамдинням танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэний дагуу санал хураалт явуулав.*

**Г.Мөнхцэцэг:** 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.3” гэснийг, 6.14 дэх хэсгийн “тусгай” гэснийг тус тус төслөөс хасаж, 6.2 дахь хэсгийн “бие даан ажил” гэснийг “хувиараа” гэж /цаашид тохиолдол бүрд/, 6.5 дахь хэсгийг “хэмжих ба багц цагийг дараагийн түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ” гэснийг “тооцох бөгөөд дараагийн

боловсролын түвшинд дүйцүүлнэ” гэж, 6.6 дахь хэсгийн “багц цаг” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг” гэж, 6.8 дахь хэсгийн “ажил олгогчийн” гэснийг “түншлэлийн” гэж өөрчилж, 6.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 6.15 дахь хэсэг нэмэх:

“6.11.Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.15.Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Үнэлгээ, баталгаажуулалт” гэснийг “Чанарын баталгаажуулалт” гэж, 8.2 дахь хэсгийн “Хүний өмнөх мэдлэг, ур чадвар, чадамжийг” гэснийг “Эзэмшсэн мэдлэг, ур чадварыг” гэж өөрчилж, 8.1 дэх хэсгийн “суралцагч” гэсний өмнө “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дахь хэсгийг нэмэх:

“8.3.Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

8.4.Магадлан итгэмжлэлийг Боловсролын ерөнхий хуулийн 17.12-т заасан байгууллага мөн хуулийн 30.1.12-т заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ.

8.6.Боловсролын ерөнхий хуулийн 29.1.8-д заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

8.7.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 40.7-д заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “63.1, 63.2, 63.3 дахь заалтад” гэснийг “63 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилж, төслөөс 11.6, 11.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1 Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоонд Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д зааснаас гадна хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 22 дугаар зүйлийн гарчиг, 22.1 дэх хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/” гэж, 22.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хэсгийн “бүрдэнэ” гэснийг “бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна” гэж, 22.3, 22.5 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 22.6 дахь хэсгийн “Засгийн газарт” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан үндэсний зөвлөлд” гэж, төслийн 22.9.5 дахь заалтын “эдийн засгийн” гэснийг “эрэлттэй болон” гэж өөрчилж, мөн зүйлийн 22.8 дахь хэсгийг төслөөс хасаж, 22.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Зөвлөлийн даргыг мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүний олонхын саналаар томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтын “их сургууль, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, 23.1.4, 23.1.7 дахь заалтын “тусгай” гэснийг, 23.1.8 дахь заалтын “энгийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 2  
Бүгд: 10  
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

7.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа “Боловсролын эрхийн хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 24.1.7, 24.1.8, 24.1.9 дэх заалт, 24.2 дахь хэсэг нэмж, төслөөс 24.1.4, 24.1.5 дахь заалтыг хасах:

“24.1.7.багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг түншлэгч талуудтай хамтран зохион байгуулах;

24.1.8.багш, ажилтны мэргэжлийн зэрэг олгох ахиулах, сунгах;

24.1.9.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирлыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх.

24.2.Энэ хуулийн 24.1.7-д заасан чиг үүргийг Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчилж, төсөлд 26.5.3, 26.5.4, 26.5.5, 26.5.6 дахь заалт, 26.7 дахь хэсэг нэмэх:

“26.4.Удирдах зөвлөл нь нийт арван нэгэн гишүүнтэй байх бөгөөд Төрийн захиргааны төв байгууллагаас гурав, нутгийн захиргааны байгууллагаас гурав, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх нэг, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх гурав, суралцагчийн нэг төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5.3.мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг батлах, үр дүн, чанар, гүйцэтгэлд хяналт тавих;

26.5.4.төсвийн хязгаарт нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар цалингийн санг тогтоох;

26.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг энэ хуулийн 23.1.10-т заасан журмын дагуу сонгон шалгаруулж томилох, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.5.6.боловсролын сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх;

26.7.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.



**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Мөнхцэцэг:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 10  
Бүгд: 10  
0.00 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг “мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө” гэж, 29.4.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.3.3, 29.3.4 дэх заалт нэмэх:

“29.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын тодорхой хувь;

29.3.4.энэ хуулийн 19.4-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

***Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулав.***

**1.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн

батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**2.Боловсролын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Боловсролын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Мөнхцэцэг:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**3.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

**4.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах саналыг нэгдсэн хуралдаанд гаргах нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 35 минут үргэлжилж, 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 50 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 07 дугаар сарын 04-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 15 цаг 15 минут

### **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Мөнхцэцэг:** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2023 оны 7 сарын 4-ний өдрийн хуралдаан ирц бүрдсэн тул нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу ирцийг танилцуулах ёстой байдаг. Ингээд ирвэл зохистой 16 гишүүн байх ёстой, 9 гишүүн ирсэн байна. Тэгээд ирцийг танилцуулъя. Амгалангийн Адьяасүрэн /Баянхонгор аймаг 3 дугаар тойрог/ ирсэн байна. Пүрэв-Очирын Анужин /Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар тойрог өвчтэй байгаа юм байна. Телеуханы Аубакир /Баян-Өлгий аймаг 2 дугаар/ тойрог ирсэн байна. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг /Архангай аймгийн 1 дүгээр тойрог/ чөлөөтэй байгаа. Балжиннямын Баярсайхан /Завхан аймаг 9 дүгээр тойрог/ хараахан ирээгүй байна. Энхбаярын Батшугар /Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар тойрог/ одоогоор тодорхойгүй байна. Хассуурийн Ганхуяг /Баянгол дүүрэг 26 дугаар тойрог/ ирсэн байна. Гонгорын Дамдинням /Дархан-Уул аймаг 19 дүгээр тойрог/ ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа /Сонгинохайрхан дүүрэг 27 дугаар тойрог/ ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг /Сүхбаатар дүүрэг 24 дүгээр тойрог/ өвчтэй байна. Чинбатын Ундрэм /Сэлэнгэ 13 дугаар тойрог ирсэн байна. Ням-Осорын Учрал /Сонгинохайрхан дүүрэг 28 дугаар тойрог/ ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн /Баянзүрх 23 дугаар тойрог/

ирсэн байна. Содномын Чинзориг /Өвөрхангай аймаг 10 дугаар/ тойрог ирсэн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан /Хөвсгөл аймаг 17 дугаар тойрог/ ирсэн байна.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын дэд хороонд хүргүүлэх ёстой байгаа.

2 дугаарт. Боловсролын ерөнхий хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудал байгаа.

3 дугаарт. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудал байгаа.

Хуралдаанд хэлэлцэх асуудлаас өөр саналтай гишүүн байна уу. Байхгүй байна.

**Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна аа.**

Ажлын хэсгийг оруулаарай. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Сангийн сайд Жавхлан, Сангийн дэд сайд

Мөнгөнчимэг, Монгол Улсын ерөнхий аудитор Занданбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Аудитын нэгдсэн удирдлагын зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням, Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Тавинжил, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Дэлгэржаргал, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төрийн сангийн газрын Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Цацрал, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Цэдэвсүрэн, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Хуяцогт, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Нансалмаа, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир, Боловсролын ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Мөнхгэрэл, Боловсролын зээлийн сангийн дарга Гарди, Боловсролын зээлийн сангийн нягтлан бодогч Тамир, Соёлын яамнаас. Соёлын сайд Номин, Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Энх-Амгалан, Соёлын яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат, Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Батцэцэг, Соёлын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Бямбасүрэн, Соёлын яамны Төсвийн ерөнхий нягтлан бодогч Эрдэнэсүрэн, Биеийн тамир, спортын үндэсний хорооноос Монгол Улсын сайд, олимп, биеийн тамир,

спортын үндэсний хорооны дарга Бат-Эрдэнэ, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Баттулга, Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Гэрэл, Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Цэрэнболд гэсэн ийм бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Жавхлан хийнэ. Сангийн сайдыг танилцуулга хийхийг урьж байна. Танилцуулгыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан сайд танилцуулга хийе.

**Л.Энх-Амгалан:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 202 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн, Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 7 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17,1 их наяд, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18,1 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч төлөвлөгдсөн дүнгээс 1,8 их наядар буурсан нь сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд тус Байнгын хороонд харьяалагдах Боловсрол, шинжлэх ухааны сайд, Соёлын сайд, Биеийн тамир, спортын улсын хорооны нийт 2281 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан ба

үүнээс гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих 2059 байгууллагыг нэгтгэсэн байна. Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага болон цэвэр зээлийн дүн 3 их наяд 985 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 3 их наяд 580 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 388 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлд 16,8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Нийт зарлага болон цэвэр зээлийн дүнгийн дүн 92,5 хувь буюу 3 их наяд 689 тэрбум төгрөгийг Боловсрол шинжлэх ухааны сайд, 5,8 хувь буюу 230 тэрбум төгрөгийг Соёлын сайд, 1,6 хувь буюу 62 тэрбум төгрөгийг Биеийн тамир спортын хорооны зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 4 их наяд 41 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 40 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн санхүүжилтээр 9,5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ, та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон бусад холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж төсвийн тухай хуулийн дагуу “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалд холбогдуулаад Монгол улсын ерөнхий аудитор Занданбат танилцуулга хийнэ. Занданбат аудиторыг урьж байна. Танилцуулгыг Ерөнхий аудиторын орлогч Наранчимэг хийе 1 дүгээр микрофон дээр.

**Ц.Наранчимэг:** Улсын Их Хурлын Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 1761 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1090 байгууллагад дүгнэлт гаргаж, 669 байгууллагыг аудитын түүвэрт хамруулан шинээр байгуулагдаж үйл ажиллагаа явуулаагүй 2 байгууллагад дүгнэлт өгөөгүй болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд 988 байгууллагад өөрчлөлтгүй, 97 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өгч, 3 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзлаа. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 284,6 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 1,5 тэрбум төгрөгийн 643 зөрчил төлбөрийн акт тогтоож, 248,5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 901 албан шаардлага, 32,6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1885 зөвлөмж, 1,9 тэрбум төгрөгийн 58 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага, 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлээ.

Нийцлийн асуудлаар 123,1 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0,1 тэрбум төгрөгийн 34 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 72,3 тэрбум төгрөгийн 558 зөрчилд албан шаардлага, 50,7 тэрбум

төгрөгийн зөрчилд 693 зөвлөмж өгсөн. Нягтлан бодох бүртгэл, тайлагналттай холбоотой 899,5 тэрбум төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад задрууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1 их наяд 465,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 357 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 430 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс шилжин хэрэгжих 873,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 256, шинээр хэрэгжих 591,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 174 төсөл арга хэмжээ байна. Нийт төсөл арга хэмжээний гүйцэтгэл 60 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 81,7 хувьтай байна.

Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 460 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 180 байгууллага дүгнэлт гаргаж, 280 байгууллагыг аудитын түүвэрт хамрууллаа. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай санал, дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 156 байгууллагад өөрчлөлтгүй, 24 байгууллагад хязгаарлалттай санал, дүгнэлтийг өглөө. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,5 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 0,2 тэрбум төгрөгийн 151 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 3,9 тэрбум төгрөгийн 235 зөрчлийг арилгах албан шаардлага, 2,4 тэрбум төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 338 зөвлөмж, 10 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцлийн асуудлаар нийт 11,1 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс 8,9 сая төгрөгийн зөрчилд 13 төлбөрийн акт тогтоож, 8 тэрбум төгрөгийн 109 зөрчилд албан шаардлага, 3,1 тэрбум төгрөгийн зөрчилд 124 зөвлөмж өглөө. Нягтлан бодох бүртгэл тайлагналттай

холбоотой 5,5 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг аудитын явцад залрууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 481,2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 74,4 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 87 төсөл арга хэмжээгээр хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнээс шилжин хэрэгжих 379,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 49,1 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 62, шинээр хэрэгжих 32,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7,7 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 25 төсөл арга хэмжээ байна. Төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэл 76,9 хувьтай, санхүүжилтийн гүйцэтгэл 86,6 хувьтай байна.

Аудитын дүн дүгнэлтээс нэн тэргүүнд анхаарах асуудлуудыг тоймлон танилцуулъя. Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүйгээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнг бодитой үнэлэх боломжгүй байна.

Төсөл арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй, төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны 1 болж байна. Орхигдсон болон олон жил үргэлжилж байгаа төсөл арга хэмжээг богино хугацаанд ашиглалтад оруулах шийдлийг гаргахгүй байгаа нь төсвийн хөрөнгө үр дүнгүй зарцуулагдах үр дагавар үүсэхээр байна. Гадаад дотоод



зээлийн эх үүсвэр болон Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөс иргэн, хуулийн этгээдэд олгосон зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд байршуулаагүйгээс хэд хэдэн эх үүсвэрээс давхардуулан зээл аван зээлийн баталгаа чанаргүй болж, гэрээний үүргийг хэрэгжүүлэхгүй зээлийн эх үүсвэр бүрдэхгүй байх эрсдэл нэмэгдэж байна. Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, мөн төсөвт ачаалал үүсэж буй талаар жил бүрийн аудитаар өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа тул Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй зөрчсөн хэвээр байна.

Аудитын дүн, дүгнэлтийг танилцуулаа. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Баярлалаа. Танилцуулгуудтай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу. Нэрсээ өгье. Жаргалмаа гишүүнээр тасаллаа. Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

**Х.Ганхуяг:** Би нэг товчхон асуулт асуучихъя. Манай Баянгол дүүргийн 10 дугаар хороолол буюу 6 дугаар хороонд “Эрдмийн өргөө” гээд сургуулийн өргөтгөл баригдаж байгаа, 640 хүүхдийн. Тэгээд 7 жил баригдаж байна. Тэгээд ашиглалтад ордоггүй, тэгээд очоод уулзахаар яамнаас нь мөнгийг нь татчихсан гэж ярина. Эсвэл очоод уулзахаар аудитаас дүгнэлт хүлээгдэж байна гэж яригдана. Тэгээд ийм эзэн бие олдохгүй. Уг нь бол бид нар жил болгон төсвийн юун дээр нь тодотголыг нь хийгээд л шаардлагатай мөнгийг нь тавиад л явдаг юм. Тэгээд 1 бол гүйцэтгэгч нь болохгүй байгаад байна уу, эсвэл мөнгө нь татагдчихаад байна уу. Яг юу болоод байгаа юм надад тодорхой хэлээд өгөөч.

**Г.Мөнхцэцэг:** Ганхуяг гишүүний асуултад Боловсролын яамнаас Хуягцогт

дарга хариулъя. 4 дүгээр микрофон дээр очоод суучих.

**О.Хуягцогт:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт. Баянгол дүүргийн “Эрдмийн өргөө” цогцолбор сургуулийн 640 хүүхдийн суудалтай барилгын өргөтгөл 2018 оны төсөвт анх туссан. Төсөвт өртөг бол 5,7 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн. Гүйцэтгэлийн хувь бол 85 хувьтай, 2023 онд санхүүжих дүн 346,4 сая төгрөг гэж батлагдсан. “Солид констракшн” гэж компани гүйцэтгэж байгаа ажил байна. Барилгын үндсэн хийц бүтээцийн ажлууд хийгдэж дууссан. Барилга дулаанаар хангах зөвшөөрөл авч холбосон, дотор заслын ажил хийгдэж байгаа ийм явцтай байна. Энэ компанийн хувьд санхүүжилтийн хувьд 2023 онд 346,4 сая төгрөгийн санхүүжилт туссан. Шаардлагатай санхүүжилт бол 942 сая төгрөг шаардлагатай гэсэн ийм хүсэлт ирүүлсэн байна. Ингээд нийт авсан санхүүжилт бол 4,8 тэрбум. Энэ жилийн хувьд 3 ээлжийн сургуулиудыг ачаалал өндөртэй сургуулиудын барилгын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Засгийн газраас 6 дугаар сард тогтоол гарсан. Үүний хүрээнд барилгын ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлж, шаардлагатай бол Төсвийн тухай хуульд заасны дагуу гүйцэтгэл санхүүжих дүнгээс нэмж гарсан тохиолдолд Сангийн яамны зөвшөөрлөөр ингээд зохицуулалт хийж олгох ийм зохицуулалтыг хийж ажиллаж байна.

**Г.Мөнхцэцэг:** Ганхуяг гишүүн тодруулъя.

**Х.Ганхуяг:** Боловсролын хөрөнгө оруулалтыг шалгах ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж л байсан л даа би 2021 онд ч ажилласан, 2022 оны төсвийн боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг хариуцаж ажлын хэсгийн ахлагчаар нь ажилласан л даа. Тэгээд шаардлагатай мөнгийг нь бүгдийг нь

тавьж өгсөн. Тэгээд Сангийн яам дээрээ байгаа юм уу. Танай Боловсролын яаман дээр байгаа юм уу. Надад тэр сургуулийг л ашиглалтад оруулаад өгчих. Наадах чинь Монгол Улсын хамгийн олон сурагчтай сургууль байхгүй юу. Хамгийн олон сурагчтай. Тэгээд тэр нэг ийм жижигхэн өргөтгөлийг чинь хэдэн жил барих юм бэ. Тэгээд тэр газар дээр нь очиж танилцана. Тэгэхээр Сангийн яам мөнгийг нь татчихлаа гэж хэлнэ. Сангийн яамнаас тодруулахаар Боловсролын яамнаас тодруулаач ээ гэнэ. Тэгээд ингээд асуухаар дахиад л нэг тодорхой бус юм яриад байх юм. Яг хэзээ ашиглалтад орохыг л надад хэлээд өгчих.

**Г.Мөнхцэцэг:** 4 номерын микрофон дээр Хуягцогт дарга хариултаа өгөөрэй.

**О.Хуягцогт:** Ер нь бол 2024 онд шилжиж дуусахаар төлөвлөгдсөн. Үлдэгдэл санхүүжилт бол 792 сая төгрөг дутуу, энэ нь 2024 оны төсөвт тусна. Энэ төсөвт тусах дүнг сая би хэллээ. Хэрвээ гүйцэтгэлээ эрчимжүүлж чадах юм бол энийг 2023 онд ашиглалтад оруулж, шаардлагатай санхүүжилтийг нь 2023 оны төсөвт зохицуулалт хийж хэрэгжүүлэх боломжтой байна. Энэ дээр бол Боловсролын ерөнхий газраас ажлын хэсгүүд гараад дүүргүүдтэй хамтраад яг энэ ачаалал өндөртэй сургуулиуд дээр барилгын ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх ийм ажлууд хийгдэж байна. 84 хувийн гүйцэтгэлтэй. Тэгэхээр энэ гүйцэтгэлээ 90, 95 болгосон тохиолдолд ирэх онд шилжих 792 сая төгрөгийг энэ жилийн төсөвт олгох боломжтой байгаа юм эрх зүйн хувьд. Тэгэхээр энийг бол зөвхөн нэг яам биш дүүрэг холбогдох яамдууд ингээд хамтраад хэрэгжүүлэх ийм бүрэн боломжтой шийдэл нь бол байгаа юм байгаа юм.

**Г.Мөнхцэцэг:** Боловсролын салбарт ийм хөрөнгө оруулалтууд шаардлагатай байгаа зүйлүүд барилга байгууламжууд хөдөө орон нутгуудад ч бас байгаа.

Тэгээд ер нь бол нэгдсэн байдлаар Энх-Амгалан сайд дүгнээд нэг хэлчихье дээ.

**Л.Энх-Амгалан:** Манай боловсролын салбарт нийт 2023 онд 399 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа юм. Үүнээс барилга 361, засвар 21, тоног төхөөрөмж 16 гээд ингээд ийм нийт төсөвт өртгөөрөө 1,8 их наядын төсөвт өртөгтэй, үүнээс санхүүжих дүн нь 529 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй ийм арга хэмжээнүүд хийгдэж байгаа юм. Тэгэхдээ яах вэ, зовлон тоочихмооргүй байгаа юм. Гэхдээ бид нар чинь яг 2022 оны Засгийн газрын аудитын үнэлгээ ярьж байгаа учраас ерөнхийдөө 2021, 2022 он оны цаг үе чинь бол нэг ковидын үед тарчихсан байсан нөхцөл байдал гарсан учраас энэ дээр нөгөө хөрөнгө оруулалттай холбоотой нэлээн их хүндрэлүүд гарсан юм байгаа юм. Тэгээд ганцхан Ковид руу бас бүх юмыг буруу чихэж болохгүй. Ерөнхийдөө ганцхан манай боловсролын салбарын хөрөнгө оруулалт ч биш, соёлын салбарын хөрөнгө оруулалт, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, биений тамирын салбарын хөрөнгө оруулалтуудыг ер нь цаашидаа бид нар хөрөнгө оруулалтын төлөвлөлтүүдийг ер нь яг яаж хийх ёстой юм бэ, яаж гүйцэтгэл гаргах ёстой юм, яаж хянах ёстой юм, яаж санхүүжилтийг хийх ёстой юм бэ гэдэг ийм тогтолцооны шинэчлэлийн асуудлуудыг бид нар яг ярихгүй бол эргээд нэг ийм баахан дуусдаггүй, олон жил дамнасан ийм тогтолцоо болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр мэдээж Сангийн яамтай өнгөрсөн хугацаанд ярьсан нэг зүйл бол ерөөсөө улсын төсөв батлагдахаасаа эхлээд зөв батлагдах ёстой юм байна. Тэр нь бол яг нөгөө ТЭЗҮ-үүд нь гарчихсан, газрын зөвшөөрлүүд нь олгочихсон, тэгээд ер нь бол Сангийн яамтай ярьж байгаа нэг зүйл нэг объектын санхүүжилтийг 3 жил жил дотроо л ер нь дуусгаж байя. Хамгийн урт хугацаандаа 3 жил дотроо.

Тэгэхгүй бол бид нар нөгөө Улсын Их Хурал дээр төсөв батлагдахдаа төсөвт өртгөөр нэг том дүн тавьчихдаг. Жишээ нь юу гэдэг юм 950 хүүхдийн сургуулийг төсөвт өртөг нь 10 тэрбум гэж тавьчихаад, тэрнээс санхүүжих дүн нь 1 тэрбум дээр гээд тавьчихдаг. Тэгээд ажил эхэлдэг. Дараагийн жил нь дахиад төсөв гээд ингээд нэг дусаагаад дусаагаад ингэж явсаар байгаад эргээд нөгөөдөх нь их олон жил ингээд дуусдаггүй ийм зовлон байгаа учраас ерөнхийдөө бид нар төсвийнхөө төсөл, төлөвлөлтүүдийг хийхдээ их зөв төлөвлөдөг болъё гэж ийм тогтолцооны шинэчлэл рүү бид нар алхаад байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ. Тийм учраас Улсын Их Хурал дээр жил бүхэн тухайн дараагийн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлахад жагсаалтуудаа баталчихдаг. Тэр жагсаалтууд нь салбар салбаруудын яамнуудаас нь Сангийн яамд очиж нэгтгэгдээд тэр нь яг нөгөө улсын төсвийг Монгол Улсын Их Хуралд өргөн баригдахад тавигдах ёстой хөрөнгө оруулалтын шаардлагуудыг нь дагасан ийм хөрөнгө оруулалтуудыг л Их Хурлын гишүүд бид нар батлуулж баймаар байгаа юм аа. Энэ бол том сэтгэлгээний хувьд, хандлагын хувьд нэлээн том соёл болох асуудал юм. Саяын Ганхуяг гишүүний яриад байгаа “Эрдмийн өргөө” гэдэг цогцолбор чинь яг үүний жишээ байгаа байхгүй юу. Энийг бол ингээд саяын Засгийн газрын хуралдаан дээр бид нар оруулж, ер нь Монгол Улсад 3 ээлжид орох эрсдэлтэй байгаа улсын хэмжээнд 80 гаруй сургуулиуд байгаа. Үүнээс Улаанбаатар хотод 40 гаруй сургуулиуд байгаа. Ингээд энэ жил бид нар ер нь 3 ээлжид орох гэж байгаа эрсдэлтэй сургуулиуд дээр ер нь яам, Засгийн газар, нийслэл бол онцгойлон анхаарч тодорхой шийдлүүдийг гаргая гэж. Тэгэхээр үндсэндээ бид нар чинь нэг эргээд харахаар яг төсвийнхөө хуульд захирагдах ёстой учраас гүйцэтгэгч нар дээр ямар асуудлууд үүсдэг вэ гэхээр яг тухайн жилд санхүүжүүлэх дүн нь саяын “Эрдмийн өргөө” цогцолбор дээр чинь

энэ жил санхүүжих дүн нь 640-хөн сая төгрөгтэй байгаа байхгүй юу. Тэр компани 640 саяыг хийгээд л гүйцэтгэлээ гаргаад л энэ мөнгийг авах ёстой. Гэтэл цаана нь объектыг дуусгаад дахиад тэрбум төгрөгийн санхүүжилт хэрэгтэй байдаг. Тэр нь ирэх оны төсөв хүлээнэ гэх юм дахиад нөгөө объект чинь нэг жилээр хүлээгдчих ийм асуудал гарч байгаа учраас бид нар сая Монгол Улсын Засгийн газар дээр 3 ээлжийн сургуулиуд дээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ дээр онцгойлон авч хэрэгжүүлэхийн тулд төсвийн ерөнхийлөн захирагч нарт тодорхой эрхүүд хуулийн хүрээнд олгогдож, гүйцэтгэл муутай байгаа объектоос гүйцэтгэл сайтай байгаа тэр тусмаа 3 ээлжийн эрсдэлд.../минут дуусав/

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайдад баярлалаа. Ундрaм гишүүн асуултаа асууя.

**Ч.Ундрaм:** Би бас яг тодорхой хэдэн сургууль, цэцэрлэг асуумаар байна. Мандал сумын 3 дугаар сургуулийн өргөтгөл 3,8 тэрбум төгрөг энэ жил тавигдсан, гүйцэтгэл 0, Сүхбаатар сумын 4 дүгээр сургууль 3,1 тэрбум төгрөг энэ жил тавигдсан, гүйцэтгэл 0, Орхонтуулын Рашаант тосгонд байдаг цэцэрлэг бас одоо хүртэл ашиглалтад ороогүй өчнөөн жил болж байна. Энэ дээр дахиад энэ жил нэмэгдээд Баруунбүрэн сумын албан бус боловсролын төв гүйцэтгэл 0 гэж байна л даа. Тэгэхээр энэ гацаад байгаа газруудыг та хэд ажлын хэсэг гаргаад, очиж хараад компани гүйцэтгэгч компанитай нь уулзаад, ингээд ажлыг хурдасгах тал дээр ямар нэгэн авсан арга хэмжээ байна уу. Энэ Мандал сумын 3 дугаар сургууль, Сүхбаатар сумын 4 дүгээр сургууль дээр би бол бүр 3 жил ярьж явж байна шүү дээ. 2020 оноос авхуулаад л жил болгон ярьдаг, тэгээд л юу ч урагшаа явдаггүй, юу ч хийгддэггүй. Тэгээд цаана чинь өчнөөн хүүхдүүд шахалдаад л нэг ангид олноороо суугаад л багтахгүй ингээд байгаад байна.

Тэгэхээр энэ яамны зүгээс энийг хурдлуулах тал дээр яг ямар арга хэмжээ авсан бэ. Яг хэзээ ашиглалтад орох вэ гэдгийг надад маш тодорхой хэлээд өгөөч.

2 дугаарт Шинжлэх Ухаан, Технологийн сан хязгаарлалттай дүгнэлт гарсан байна аудитын. Энэ сангийн үйл ажиллагааг сайжруулах тал дээр Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ямар ажил хийгдсэн бэ. Сангийн мөнгө, төгрөгөөр ямар мундаг дэвшилтэт судалгаа, технологи өнгөрсөн хугацаанд гарч ирсэн бэ Монгол улсад.

3 дахь асуулт нь албан шаардлага өгөөд хэрэгжүүлдэггүй аудитын дүгнэлт гараад энийг нь ерөөсөө ингэж ажил хэрэг болгодоггүй гээд сая Ерөнхий аудитор уншиж байна л даа. Тэгээд ингээд байгаа нөхдийг яах ёстой юм. Албан шаардлага хүргүүлээд энд нь арга хэмжээ авахгүй байвал яах ёстой юм. Хэрвээ ингэхгүй юм бол бид нар бүр аудитын дүгнэлт хийлгээд ч хэрэггүй юм биш үү. Аудитын шалгалт хийлгээд. Энийг бүр хуульчлаад, арга хэмжээ авдаг болмоор байх юм. Өөр бүр зөрчлийн ч байдаг юм уу ийм арга хэмжээ авдаг болгохгүй бол дүгнэлт гараад л байдаг, албан шаардлага хүргүүлээд л байдаг тэгээд юу ч хийдэггүй төсвийн ерөнхийлөн захирагч нар нь ч байдаг юм уу тээ тэр хүмүүс нь. Энэ дээр яг яах ёстой юм бэ гэсэн ийм 3 асуулт байна.

**Г.Мөнхцэцэг:** Ундрам гишүүний Шинжлэх Ухаан, Технологийн сантай холбоотой асуудлыг нь эхлээд Энх-Амгалан сайд хариулъя, дараагийн тэр Сэлэнгэ аймагт байгаа хөрөнгө оруулалттай холбоотой, барилга байгууламжуудтай холбоотой, гүйцэтгэлтэй холбоотой асуудлыг нь бэлдэж байгаарай. Дараа нь аудитын дүгнэлттэй холбоотой асуулт тавьсан. Энэ 3 асуултад ээлж дараалаад хариулаад явчихъя. Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Би Шинжлэх Ухаан, Технологийн сантай холбоотой асуудлаар хариулт өгчихье. Хуягцогт дарга тэр Ундрам гишүүний тойргийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудал дээр нэмэлт хариултаадыг өгчхөөрэй.

Тэгэхээр ер нь бол Ундрам гишүүн ээ, Засгийн газрын тусгай сангууд бол маш их хаалттай байлаа шүү дээ. Жил бүхэн ер нь өнгөрсөн хугацаанд ямар мөнгөө зарцуулагдаж байсан юм. Тэрүүгээр ямар ажлууд хийгдсэн юм, сонгон шалгаруулалт нь ямар байсан юм, үр дүн нь яаж гарсан юм бэ гэдгийг бид нар бүгдээрээ та бид нар Улсын Их Хурлын гишүүд байхдаа ч гэсэн ингээд ийм чих нь дүлий, нүд нь хаалттай маягаар л явж ирсэн. Ингээд Монгол Улсын Засгийн газраас тодорхой шийдвэрүүд гарч “5ш” ажиллагааны хүрээнд бид нар Засгийн газрын тусгай сангуудыг бүгдийг нь ил болгосон байгаа. Одоо хэн ч өнөөдөр Засгийн газрын тусгай сангуудын өнгөрсөн хугацаанд хийсэн санхүүжилт, сонгон шалгаруулалтаар бол шүгэл үлээх эрх нь бүгдээрээ нээгдсэн. Тэрэнтэй адилхнаар Шинжлэх Ухаан, Технологийн санг би энэ ажлыг аваад, тэгээд энэ сан дээр өнгөрсөн 15, 16 жилийн турш нийт улсын юугаар энд чинь бараг үндсэндээ 170-аад тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байгаа юм. Өнгөрсөн 15 жилийн хугацаанд 170 тэрбум төгрөгийн. Яах вэ жил бүхэн үндсэндээ 10-12 тэрбум төгрөгийн санхүүжилт хийдэг л сан шүү дээ. Тэгээд ямар ч байсан 170 тэрбум төгрөгөөр яг юу хийсэн бэ гэж. Тэгээд 170 тэрбум төгрөгөөр 4000 гаруй судалгааг санхүүжүүлсэн байна. Суурь судалгаа санхүүжүүлсэн байна. Хэрэглээний судалгаа, салбарын судалгаанууд санхүүжүүлсэн байна. Тодорхой үр дүнгүй төрсөн судалгаанууд маш их байгаа. Энийг бас би өөрөө Байнгын хороо дээр бас хэлж байсан. Хэд хэдэн зүйлүүдийг хэлж байсан. Жишээ нь гэхэд Дарханы 144 дүгээр гэдэг сорт 10 хэдэн тэрбум төгрөгийн судалгаагаар бий болсон сорт бий болоод өнөөдөр

Монгол Улсын газар тариалангийн бүтээмжийг нэмж байгаа. Жил бүхэн ургац алдалтыг 40 хувь бууруулж байгаа ийм сорт байна шүү дээ. Жил бүхэн бараг үндсэндээ газар тариалангийн салбарт чинь 60 орчим тэрбум төгрөгийн шинэ бүтээмж бий болгож байгаа, газар тариалангийн салбарыг өрсөлдөх чадвартай болгож байгаа ийм сайн судалгаа жишээ нь байна. Монгол Улсад элэг шилжүүлэн суулгах бүх технологи судалгаануудыг мөн Шинжлэх Ухаан, Технологийн сангаар хийгдсэн байдаг. Энэ бол маш том дүн үр дүнгээ өгч байна. Ер нь бид нар эргээд нийт хийчихсэн судалгаа өнөөдөр хэд нь инновац болоод яг амьдралд, эдийн засагт нэвтэрч чадсан юм бэ гэдэг эдийн засгийн үзүүлэлтүүдийг бид нар ерөөсөө хийж чадаагүй юм байна лээ. Тийм учраас иргэдийн дунд байгаа шинжлэх ухааны тухай ойлголт, шинжлэх ухаанд зарцуулж байгаа мөнгөний үр ашгийг тооцох тэр ойлголтууд бол бүдэг байдаг нь их ойлгомжтой. Тийм учраас бид нар жил бүхэн ер нь улсын төсөв батлагдахад Эдийн засгийн байнгын хороо, манай Байнгын хороо, Инновацын байнгын хороонд хамтарч, тухайн жилийн шинжлэх ухаан технологийн зээлийн сангаас анх санхүүжигдсэн энэ санхүүжилтийн тайланг тавьж байга гэсэн ийм юутай байгаа.

Шинжлэх Ухаан, Технологийн сан дээр юу шинээр бий болсон бэ гэхээр одоо Шинжлэх Ухаан, Технологийн сангаар санхүүжигдэх судалгааны ажлуудыг сонгон шалгаруулдаг журмууд өөрчлөгдсөн байгаа. Журмууд өөрчлөгдсөн. Хуучин ингээд нэг ийм жилд 12 тэрбум төгрөг өгдөг, тэрийг ингээд тэгшитгээд хуваачихдаг. Тэгээд 1 судалгаа дунджаар 14 сая төгрөгөөр санхүүжүүлдэг, тэгээд 14 сая төгрөгөөр санхүүжүүлсэн судалгаанаас бид нар ер нь ямар үр дүн нэхэх билээ. Тэгээд дараагийн тэр суурь судалгаанууд чинь хамгийн багадаа 5-8 жилийн суурь судалгааны санхүүжилтийн эх үүсвэр хэрэгтэй болдог. Ингээд нөгөө жил

бүхнийхээ санхүүжилтээс болоод улс эх орны хөгжил дэвшилд хэрэгтэй байгаа суурь судалгаанууд маань тогтвортой санхүүжилт авч чаддаггүй учраас эрдэмтдийн чадвар нь дээшилдэггүй, нөгөө хийж байгаа судалгааных нь үр ашиг нь яг аж үйлдвэрийн салбар дээр нэвтэрч чаддаггүй ийм зовлон байсан учраас бид нар энэ суурь судалгааг санхүүжүүлдэг, мэдээж салбарын улс орны нөгөө шинэ сэргэлтийн 6 бодлогод хэрэгцээтэй шаардлагатай байгаа судалгааг санхүүжүүлдэг, тэгээд цаашидаа их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг дэмждэг энэ тогтолцоо дундын лаборатори дээр хийсэн судалгаанууд, их, дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудын эрдэм шинжилгээний ажлуудын хамтарсан судалгааг санхүүжүүлдэг ийм журмууд.../минут дуусав/

**Г.Мөнхцэцэг:** Хуягцогт дарга үргэлжлүүлээд саяын асуусан асуултуудад нэмж хариулаарай.

**О.Хуягцогт:** Ундрам гишүүний асуултад Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Хуягцогт хариулж байна. Сэлэнгэ аймгийн Мандал, Сүхбаатар сумын сургуулиуд 640, 320 хүүхдийн хүчин чадалтай сургуулиуд бол 2019 оны төсөвт анх туссан. Орхонтуул сумын цэцэрлэг бол 2018 онд туссан. 2 сургуулийн хувьд 2019 онд туссан боловч ковидын үеийн нөхцөл байдлаас үнийн өсөлтүүд нэлээн гарсан. Анхны төсөвт өртөг бол Мандал сумынх 3,8 тэрбум төгрөг, Сүхбаатар сумын сургуулийнх бол 3,1 тэрбумаар батлагдсан байсан. Барилга угсралтын ажлын явц Мандал сумынх 30 хувьтай, Сүхбаатар сумын сургууль бол 5 хувьтай ийм гүйцэтгэлтэй байна. Төсөвт өртөг бол нэлээн ихээр нэмэгдэх ийм үр дагавар бий болсон учраас Улсын Их Хурлын өнгөрсөн 2022 оны 72 дугаар тогтоолоор бол ковидын үед үүссэн нөхцөл байдал зөвхөн материалын үнийн өсөлтөөс бусад

шалтгаанаар үүссэн үнийн өсөлтийг Үндэсний аудитын газраар магадлал хийлгэж, ирэх 2024 оны төсөвт тусгах ийм чиглэл өгсөн. Үүний дагуу яам холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтраад магадлуулах, ингээд төсвийг нь нэмж батлуулах ийм ажил хийж байна. 2 сургуулийн хувьд гүйцэтгэгч компаниудтай бол гэрээ нэг нь цуцлагдсан, нэг нь цуцлагдах мэдэгдэл өгсөн байгаа. Яагаад гэхээр анхны гэрээнд заасан үүргүүд биелэгдээгүй учраас. Ингээд 2024 оны төсөвт үлдэгдэл хөрөнгө батлагдаад, сонгон шалгаруулалт зарлагдана. Орхонтуул сумын тэр Рашаант тосгоны цэцэрлэг гүйцэтгэл нь яваад энэ намартаа ашиглалтад орно гэсэн ийм мэдээлэл байна.

Баруунбүрэн сумын Насан туршийн боловсролын төвийн барилга, байгууламжтай холбоотой гэрээ байгуулагдсан. Энэ намартаа ашиглалтад оруулахаар манай холбогдох байгууллагууд гэрээний хэрэгжилтээ хяналт тавиад ажиллаж байна.

**Г.Мөнхцэцэг:** Аудитын дүгнэлттэй холбогдуулж асуулт асуусан. Наранчимэг дарга хариулах уу. 1 номерын микрофоныг өгье.

**Ц.Наранчимэг:** Ундрам гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд Аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан зэрэг тохиолдлуудаар бол хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлэх. Одоогийн мөрдөгдөж байгаа хууль маань ийм зохицуулалттай. Аудитаар татгалзсан санал, дүгнэлт өгсөн бол ажлаас халах гэсэн ийм 2 зохицуулалттай байгаа. Тэгэхээр бид Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж, олон улсад бол аудитын дээд байгууллагын гишүүн орнууд аудитын байгууллагаасаа өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

гаргах хугацаатай, тэрний биелэлтийг хангах үүрэгтэй байдаг. Тийм учраас хуульд бас өөрчлөлт оруулах саналыг мөн хүргүүлсэн. Мөн төсөв захирагч нарыг томилохдоо өмнө нь ажиллаж байсан газартаа санхүүгийн зөрчил гаргасан, аудитын байгууллагаас өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тохиолдолд бас дахиж төсөв захирагч буюу гарын үсэг зурдаг албан тушаалтнаар томилдоггүй байх ийм шаардлага бол зайлиггүй байгаад байгааг аудит тайландаа дурдаад байгаа.

Дараагийн нэг асуудал нь гараад байгаа зөрчлүүд дээр Төрийн аудитын байгууллагаас гаргаж байгаа тайлан дүгнэлт, зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актыг төсөв захирагч нар зөвхөн санхүүгийн ажилтны үүрэг мэт ойлгоод байгаа нь энэ зөрчил буурахгүй байгаа гол шалтгаан болж байгаа гэсэн ийм шалтгаануудыг аудитын байгууллагаас жил бүр илрүүлж, тайландаа бол тусгаж байгаа.

**Г.Мөнхцэцэг:** Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Засгийн газраас сургууль, цэцэрлэгийг хүртээмжтэй болгох талаар бүхий л талын арга хэмжээ авч байгаа боловч хөдөө орон нутгаас шилжин ирж байгаа шилжин ирэгсдийнхээ хүүхдүүдийн сургуулийн асуудлыг бид нар бас шийдвэрлэхэд хүндрэлтэй байдал үүсээд байгаа. Сонгинохайрхан дүүргийн хувьд алслагдсан дүүрэг, нөгөөтээгүүр бас захын дүүрэг гэдэг томьёоллоороо шилжин ирж суурьшиж байгаа иргэд бас олноор байгаа. Уг нь 33 дугаар хороо буюу Тахилтад бид нар бас сургуулиа бас 2 ээлжид оруулаад 1 жилийн хугацаа өнгөрсөн боловч дахиад л 3 ээлж рүү орох ийм эрсдэлтэй сургуулийн жагсаалтад орчхоод байгаа. Гэтэл манай дээр хийгдэж байсан 33 дугаар хорооны сургуулийн асуудал, 20 дугаар хорооны сургуулийн асуудал, 22 дугаар

хорооны цэцэрлэгийн асуудал бас яг ингээд бас үлдчихээд байгаа юм. Нөгөө талаар бас нөгөө Эмээлтэд байдаг 32 дугаар сургуулийн маань барилга гүйцэтгэгч компанийн хариуцлагагүй байдлаас шалтгаалан хөрөнгөө эргүүлэн татуулсан ийм нөхцөл байдал үүсээд байгаа. Уг нь энэ жилдээ бид нар бас эдгээр сургуулиудаа бүрэн гүйцэт хүлээн авах боломж байгаа боловч уу гэж би харж байгаа. 32 дугаар хороонд баригдаж байгаа сургууль 95 хувийн гүйцэтгэлтэй боловч бас хэдэн төгрөгийн дутуугаас шалтгаалаад ажил зогсчихоод байгаа. Тэгээд энэ ажлуудыг бас яаралтай явуулж, 9 сарын 1 гэхэд хүлээн авах тэр боломжоор нь Боловсролын яам бас хангаж өгөх боломж ер нь хэр байна вэ гэдэг ийм асуултууд тавих гэсэн юм. Болж өгвөл зээл тусламжид хамруулдаг юм уу, хөрөнгө мөнгөнийх нь асуудлыг шийдвэрлэж өгөөч ээ гэдэг ийм хүсэлт тавья.

Өнгөрсөн жил бас би хүсэлт тавьж байгаад уг нь сургуулиудынхаа тоног төхөөрөмж, багш нарын компьютер, сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлүүлэе гээд уг нь тавьсан юм. Тэгээд энэ тайлан дээр бас яг тэр жагсаалт маань байхгүй байх юм. Тэр ямар учиртай юм бол. Энд хариулж өгөөч.

2 дугаарт Соёлын яамнаас бас нэг хэд хэдэн зүйлийг асууя. Соёлын яамны аудитын дүгнэлт тайланг харахаар бас маш их зөрчил илэрсэн байх юм. Төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлийг зөрчөөд л 8,6 сая төгрөг, 9 дүгээр зүйлийг зөрчөөд л 0.9 сая, 12 дугаар зүйлийг зөрчөөд 156,5 сая төгрөг, 20 дугаар зүйлийг зөрчөөд 652,1 сая төгрөг нийтдээ 1 тэрбум 165,3 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн гэсэн байх юм. Одоо энэ зөрчлийг ер нь яаж арилгуулах ёстой юм бэ. Төсөв дээр бид нар уг нь Байгалийн түүхийн музей гээд Ерөнхий сайд Хүрэлсүх даргын үед л уг нь Байгалийн

түүхийн музейн асуудлыг шийдвэрлэлээ гэдэг ийм мэдээлэлтэй байсан боловч өнөөдрийг хүртэл ажил нь яваагүй. Бидэнд байгаа мэдээллээр 5, 6 удаа тендер зарлагдсан боловч тендерт шалгарсан компани байхгүй гэдэг байдлаас шалтгаалан ажил нь явдаггүй. Уг нь жил болгон л бид нар төсөвт нь мөнгийг нь тавиад өгчихдөг. 94 тэрбум 406 сая төгрөгийг уг нь тавиад өгчихсөн боловч ажил нь явахгүй байх юм. Энэ ямар шалтгаан байгаа юм бэ. Энийг нэг хэлж өгөөч.

Хүүхдийн номын сан гэдэг нэг өрөвдөлтэй байгууллага байдаг. Уг нь бид нар бас хүүхдүүдийг соён гэгээрүүлэх, ном соёлоор хөгжүүлэх ажлын бас томоохон хариуцлагыг үүрч явдаг Хүүхдийн номын ордон дээр бас ер нь төсөв мөнгө гэж байдаг юм уу. Энэ дээр бид нар эргээд Хүүхдийн номын санг төсөв хөрөнгөтэй болгох, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх тал дээр ер нь ямар ажил яа хийж байгаа юм бэ. Өглөө Нийгмийн бодлогын байнгын хороо дээр бас аудитын дүгнэлт гараад, дүгнэлтээ танилцуулаад хариуцлага тооцдог механизм нь ер нь хаанаа байдаг юм бэ гэдэг зүйлийг асуусан. Ер нь бусад хууль зөрчил хариуцлагын хуулиараа шийдэгдээд явна гэдэг ийм зүйл байдаг. Зүгээр нэг аудитын дүгнэлт сонсоод өнгөрөх биш, бид нар дараа нь энэ үрэлгэн зардлыг багасгах тал дээр ер нь ямар арга хэмжээ авах ёстой юм бэ гэдэг зүйлийг л бид нар бас зайлшгүй ярих шаардлагатай болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр аудитаас ер нь яг хуульд ямар зүйл заалт оруулсан юм, ямар хүсэлт тавьсан юм бэ гэдэг зүйл дээр бас яг тодорхой хариултыг өгөөч. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Жаргалмаа гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариулъя. Соёлын яам Номин сайд байна уу. Номин сайд хаачсан юм бэ. Удаа дараа ингээд Байнгын хорооны хуралд ирдэггүй. Энх-Амгалан сайд хариулж байя.

**Л.Энх-Амгалан:** Жаргалмаа сайд аа, Жаргалмаа гишүүн ээ. Сайд болох юм байна Жаргалмаа сайд гээд хэлчихлээ. Жаргалмаа гишүүний яг тойргийн хөрөнгө оруулалтын саяын сургууль, цэцэрлэгтэй холбоотой гүйцэтгэлтэй холбоотой юун дээр манай яамныхан хариулчих байх. Ерөнхийдөө бид нар өнгөрсөн жилд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд бол тодорхой ахиц дэвшил гаргасан. Ямар ч байсан Монгол Улсад сүүлийн 20 гаруй жил шийдэж чадахгүй байсан сугалааны цэцэрлэгийн тогтолцоог бид нар халсан. Энэ амжилтаа бид нар энэ жил бататгах ёстой. 1 жилийн ажил байж болохгүй. Олон жилийн тогтвортой байх ёстой.

2 дахь асуудал бид нарт 3 ээлжийн сургуулийн асуудал байгаа Жаргалмаа гишүүн ээ. Тэгэхээр энэ 3 ээлжийн сургуулиуд дээр бид нар ер нь онцгойлсон ийм бодлогын арга хэмжээ авахгүй бол жил бүхэн ийм гал унтраасан маягаар явах юм бол үүний ачааллыг ер нь дийлэхгүй юм байна. Үүний ард ч гарахгүй юм байна. Сургууль, цэцэрлэгүүд баригддаг тэр нь цаг хугацаандаа орж чаддаггүй 1-д.

2-т жил бүхэн манай яамнаас нээсэн судалгаагаар сүүлийн 6 жилд жил бүхэн 14-16 мянган хүүхдийн хүчин чадалтай сургуулийн барилга байгууламж ашиглалтад орж байгаа юм. Жил бүхэн 14-16 мянга. Гэтэл жил бүхэн сургуулийн насны хүүхэд бол 35 мянгаас 38 мянган хүүхэд шинээр нэмэгдэж байгаа юм. Тэгэхээр жилд 100 сургууль ороход цаана нь дахиад 60 сургууль шаардлагатай байх ийм л тооцоо гарч ирчхээд байгаа байхгүй юу. Тэгэхээр шинээр 1 дүгээр ангид хүүхэд ороход, 100 хүүхэд ороход 40 сургуультай 60 нь илүү 3 ээлжийн сургуулиар 1 анги танхимд олон хүүхдүүд хичээллэх ийм том эрсдэл үүсэж байгаа учраас бид нар ерөнхийдөө цаашдаа 3 ээлжийн сургуулиуд дээр бодлогын ийм томоохон арга хэмжээ авъя.

1 дүгээрт энийг дунд болон урт хугацаанд шийдэх шийдлүүд байна.

2 дугаарт энэ намрын 9 сарын 1-ээс амжиж бид нар ямар ч байсан нийслэл дээр 3 ээлжид орох эрсдэлтэй байгаа 47 сургууль дээр бүр онцгойлон анхаарал хандуулж, тэгээд мэдээж салбарын зохицуулалтууд энэ дээр шаардлагатай ийм томоохон арга хэмжээнүүдийг авъя гэж бодож байгаа юм. Бид нар дан ганц хөрөнгө оруулалтыг хүлээгээд энэ асуудал шийдэгдэж чадахгүй юм байна лээ. Тийм учраас өнгөрсөн жил цэцэрлэгийн хүрээнд авч хэрэгжүүлсэн түрээсийн цэцэрлэгийн асуудлууд, түрээсийн сургуулийн асуудлууд мөн тухайн ачаалал үүссэн байришил дээр сургуулийн болон цэцэрлэгийн бус зориулалттай байгаа барилгыг худалдаж аваад, тэрийг эс үгүй бол удаан хугацаагаар түрээслээд сургууль болгож ашиглах, анги танхимуудын зохицуулалтуудыг шинээр хийх, ер нь энэ жилээс авхуулаад бид нар 1 ангид тэр тусмаа 3 ээлжид сурч байгаа хүүхдүүдийг 1 ангид 45 хүүхдээс илүү бүлэг бүрдүүлэхийг ер нь хориглоё гэж бодож байгаа шүү дээ. Тэгж байж бид нар тодорхой боловсролын чанарын асуудлууд ярих ёстой юм байна гэж энэ тогтолцоо руу бид нар алхъя гэж байгаа юм. Эргээд сургуулиудынхаа хэв шинжүүдийг ч гэсэн бид нар задлахгүй бол одоо байгаа ирээдүй цогцолбор гэхэд ингээд 4 мянган хүүхэдтэй, 5 мянган хүүхэдтэй, 6 мянган хүүхэдтэй ийм том цогцолборын хэлбэрээр ажиллана гэдэг бол хэзээ ч тэр 1 ангид байх хүүхдийн тоо, 1 багшид ноогдох хүүхдийн тоо, боловсролыг чанартай хүргэх асуудал дээр бол бид нар ерөөсөө ахиц дэвшил гаргаж чадахгүй юм байна. Тийм учраас бид нар 3 ээлжийн сургуулийн тогтолцоог тогтолцооных нь хүрээнд үүссэн асуудлуудыг том шийдлээр гаргаж энэ асуудлуудыг шийдүүлэх ёстой юм байна гэдэг дээр бас нэлээн улс төрийн эр зориг гаргаж ажиллаж эхэлж байгаа.



Тэгээд мэдээж таны ярьсан, онцолж байгаа хэд хэдэн сургуулиуд дээр яг нөгөө бусад сургуулиуд дээр ашиглалтад ороод бараг 90-ээс дээш хувийн гүйцэтгэлтэй байгаа шүү дээ. 90-ээс дээш хувийн гүйцэтгэлтэй тэгэхдээ энэ жил санхүүжилтийн эх үүсвэр нь байхгүй байгаа сургуулиуд дээр бид нар бас тодорхой төсвийн зохицуулалтууд хийх, эс үгүй бол тодорхой хэмжээнд арилжааны банкнуудаас түр хугацааны ирэх жилийн төсөв батлагдтал түр хугацааны зохицуулалт хийх ийм ажлуудыг нийт 17 сургуулиуд дээр бид нар бас яг сургууль бүр дээр үүссэн асуудал дээр онцгойлж тухайн барилга байгууламжийг барьж байгаа гүйцэтгэгчидтэй хэлэлцээр хийж бас хэлэлцээрт орж байгаа гэдгийг бас та бүхэнд хэлье.

Тэгээд яг саяын онцолсон 2 сургуулийн гүйцэтгэл, үүсэж байгаа асуудал тэрнийхээ шийдлүүдийг бас Хуягцогт дарга хэлчих.

**Г.Мөнхцэцэг:** Үргэлжлүүлээд Хуягцогт дарга 4 номерын микрофон дээр Жаргалмаа гишүүний асуултад хариулъя.

**О.Хуягцогт:** Жаргалмаа гишүүний асуултад Хуягцогт хариулъя. Сонгинохайрхан дүүргийн хувьд 134,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа. Үүнээс нэн тулгамдаж байгаа 18 дугаар хорооны 12 дугаар сургууль, мөн 62 дугаар сургууль зэрэг 3 ээлжид орох хамгийн хүнд асуудлууд байгаа. Энэ дээр тодорхой саяын Энх-Амгалан сайдын хэлсэн шийдлүүдийг гаргахаар нийслэл, дүүрэг, яамууд хамтран ажиллаж байна. Яг тухайлан асуусан тэр 33 дугаар хорооны Тахилтын эцэст хэрэгжиж байгаа бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга 2022 оны төсөвт анх туссан. Гэрээ байгуулсан дүн нь бол 4,6 тэрбум төгрөг. 2022 болон тэрнээс өмнө төсөвт туссан төсөл арга хэмжээнүүдийн хувьд 1 хүндрэл байгаа

нь түрүүн би бас гишүүний асуултад хариулахад хэлсэн. Төсөвт өртөг нь магадлагдсан төсөвт өртөг нь дандаа нөгөө ковидын өмнөх үнэ өртөг, нөхцөл байдлаар хийгдсэн. Тэгэхээр ковидын дараах материалын үнийн өсөлт, ажиллах хүчний гээд маш олон хүчин зүйл барилгын үнийн өсөлтөд нөлөөлсөн. Тэгэхээр энэ төсөвт өртгийн зөрүү бол саяын 33 дугаар бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, мөн 32 дугаар хорооны 640 хүүхдийн сургууль. Энэ 2 дээр төсөвт өртгийн нэмэгдлийг 2024 оны төсөвт тусгаж шийдвэрлэх байдлаар ингээд дуусгана. Сургуулийн барилга 480 суудал Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны сургуулийн хувьд гадна дулааны асуудлыг шийдээд Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-тай холболт хийх зөвшөөрлийг авч, манай мэргэжлийн байгууллагууд хяналт тавьж ажиллаж байна. Тэгээд энэ ондоо багтааж ашиглалтад оруулахаар ийм хуваарьтай ажиллаж байгаа.

**Г.Мөнхцэцэг:** Соёлын яамтай холбоотой асуулт, аудитын дүгнэлт дээр гарсан зөрчлийг бас яаж арилгах ёстой юм. Ер нь Соёлын яам дээр байгаа хөрөнгө оруулалтууд дээр бас нэлээн олон асуудлууд байгаа. Тэгээд энэ дээр Энх-Амгалан Төрийн нарийн бичгийн дарга 7 номерын микрофон дээр хариулт авъя.

**Ч.Энх-Амгалан:** Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Энх-Амгалан. Манай Соёлын яам бие дааж яам байгуулагдсан цагаасаа хойш 2 дахь удаагаа аудитын байгууллагад бол тайлангаа хянуулсан. Үндсэндээ бол манай 428 байгууллага орон нутгийн өмчөөс манай Соёлын яамны харьяанд ирж, 460 байгууллага бий болсон. Энэ хүрээндээ бас хэмнэлтийн хуультай холбоотой анхан шатын баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр баримтын гүйлгээний асуудлаас болоод нэлээн зөрчлүүд бол гарсан. Энэ нь бол ялангуяа анхан шатын нэгж дээр нөгөө соёлын төвүүдэд нягтлан бодогч байхгүй,

гэрээгээр ажилладаг гэсэн гол шалтгаан бол эхний зөрчлүүд дээр бол давамгайл эзэлсэн. Дээрээс нь манай хүний нөөцийн асуудалтай холбоотой шинэ тутам санхүүгийн тайлан үйлчилгээ гаргаж байгаатай холбоотой ийм жижиг зөрчлүүд бол эзэлсэн. Ерөнхийдөө бодлогын шийдвэрийн хэрэгжилт бол манайх бол 95 хувьтай, төсвийн гүйцэтгэл бол 91 хувьтай бусад яамнуудтай харьцуулахад бол боломжийн өндөр гарсан. Тэгэхээр бид энэ онд энэ зөрчлийг арилгах үүднээс Соёлын сайдын албан даалгавар гаргасан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын төлөвлөгөө гаргуулж 9 сарын 1-ний дотор эдгээр санхүү бүртгэлийн холбоотой, мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой бичиг баримтын зөрчлүүдийг арилгуулах чиглэлээр ажлууд хийгдэж байна. Тэгээд энийг бол 9 сарын 1 гэхэд бол бид нар юуг нь гаргаж өгнө.

Байгалийн түүхийн музейн төсөв бол энэ жил 138 тэрбум болж нэмэгдсэн. Тэгээд бид он гарснаас хойш 5 удаа тендер зарлалаа. Тэгээд ингээд 2-3 оролцогч орж ирж байгаа боловч нөгөө Монгол Улсад музейн зориулалттай ийм том барилга барих ийм тендерийн шаардлага хангахуйц компани орж ирэхгүй байгаа. Тэгэхээр одоо 6 дахь тендерийг наадмын дараа зарлах гэж байна. Энэ дээр бол тодорхой шаардлагуудыг 2, 3 шаардлагыг бол бууруулж, богино хугацаанд 7 сарын 20-нд багтааж зарлахаар төлөвлөж байгаа.

3 дахь асуудлын хүрээнд Төв номын сангийн асуудал бас олон жил баригдаж байгаа. Барилгын гүйцэтгэгч компанийн эзэн нь бас ковидын үед бурхан болсонтой холбоотой нөгөө компанийн өмчлөлийн асуудлаас болоод жил гаруй ингээд зогссон. Энэ дээр бид нар тендерийг нь үлдсэн ажил дээр нь тендер зарлаад, шинээр гүйцэтгэгч сонгон шалгаруулсан. Энэ нь ажилдаа гараад 2 сарын хугацаатай ажил хийгдэж байна. Энэ ондоо бүрэн дуусгана

гэсэн ийм төлөвлөгөөтэй одоогоор өдөрт 50 орчим хүнтэй ийм төв номын сангийн ажил явагдаж байгаа. Тэгэхээр бид нар энэ намартаа багтааж ажилдаа оруулахаар ингээд төлөвлөөд явж байгаа.

**Г.Мөнхцэцэг:** Жаргалмаа гишүүн тодруулъя. Төв номын сангийн асуудал гээд л 3 жил ярьж байна. Байнгын хороо болгон дээр л энэ тайлбарыг хэлж байгаа. Тэр Үндэсний их театрын барилгын ажил гээд бас ингээд л тэр газар төлөвлөлтийнх нь хүмүүс ирчихсэн бас л бүтэхгүй байна гээд л Соёлын яамны тэр тусмаа, соёлын салбарын бүтээн байгуулалтын ажлууд ер нь бол бас ингээд өмнөх байсан газрууд нь орхигдчихсон юмнууд их олон байгаад байгаа. Энэ дээр нэгдсэн дүгнэлт гаргаад та нар гаргаад энэ юмнуудаа бас Байнгын хороогоор оруулж ирээч ээ. Гишүүн болгон л бас соёлын яг хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг ярих юм. Та нар 3 жил энэ номын сангийн барилгыг ярьж байна шүү дээ. Жаргалмаа гишүүн нэмж асуулт асууя.

**Б.Жаргалмаа:** 3 жил номын сан, 3 жил байгалийн түүхийн хүмүүс ярьж байгаа л даа. Уг нь тодорхой хэмжээний шийдэлд хүрээд, ядаж ажлыг нь эхлүүлчих юм сан. Хуягцогт дарга аа, тэр 20 дугаар хорооны “Жинст цамхаг” гэдэг ёстой нэг худлаа компани байна аа. Дулааны шугам ч байхгүй, бохирын шугам ч байхгүй барилга барьчихсан, Тэгээд энэ асуудлыг яг 9 сарын 1-нд бид нар хүлээж авах энэ зохицуулалтыг хийхгүй бол хүүхдүүд яг үнэхээр 3 буудлаас 4 буудлын холоос сургуульдаа явах ийм байдал үүсээд байгаа шүү. Үнэхээр сая сайд хэллээ. Бодлогын хэмжээнд бид нар өөрчлөлт хийхгүй бол болохгүй ээ. Хот маань тэлээд л байна, хүн ам маань төл нэмэгдээд л байна. 3 ээлжээр хичээллэе гэхээр багшлах боловсон хүчин маань байгаа билүү, зарим сургуулиудад маань бас зарим нэгэн багш дээр багшлах боловсон хүчин байхгүй эрүүл мэндийн боловсролын

хичээлээс заах багш байхгүй эмч нь ороод л биеийн тамирын багш нь ороод л явж байх жишээтэй ийм л мэдээлэлтэй байгаа. Тэгэхээр энэ тал дээр үнэхээр бодлого хэрэгтэй байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Уг нь Хүүхэд, залуучуудын театрын барилга маань овоо яваад байгаа. Гэтэл энэ дээр 100 хувь гэсэн хэр нь яг ажил бол 100 хувь ерөөсөө яваагүй. Хөрөнгө оруулалтаа материалаа татаагүй хүртэл ийм ажил байгаа байгаа шүү дээ. Тоног төхөөрөмжийн зардал ингээд 100 хувь гээд гарчихсан.../минут дуусав/

**Г.Мөнхцэцэг:** Сая Энх-Амгалан дарга сая тэгээд байна шүү дээ. Бодлого шийдвэр нь бол 98 хувьтай, хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 91 хувьтай гээд. Тэгээд энийг яаж дүгнэхээр 91 хувьтай хөрөнгө оруулалтын гүйцэтгэл байгаад байдаг юм. Энх-Амгалан сайд асуултаа асууя. Энх-Амгалан даргад нэмж харцулах юм байна уу. 7 номерын микрофоныг өгье.

**Ч.Энх-Амгалан:** Хүүхэд, залуучуудын театрын барилгын зураг бол энэ жил хийгдсэн байгаа. Хүүхдийн номын сангийн. Тэгээд энэ 2024 оны төсөвт бид суулгахаар Сангийн яам руу бол санал өгч байгаа. Юутай холбоотой төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл бол манай дээр 84 хувьтай гарсан байгаа. Сайдын багцын төсвийн гүйцэтгэл бол 91 хувьтай гарсан гэдгийг хэлэх байна.

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайд асуулт асуух гээд байсан уу.Хэнээс асуух гэж байгаа юм. Би бас тойргийн хөрөнгө оруулалттай асуудлууд зөндөө л байгаад байна л даа. Сургууль, цэцэрлэгтэй холбоотой ч байна. Соёлын төвүүдтэй ч байна. Дундговийн тэр Төв халхын дуулалт бүжгийн театр гэж 10 жил гацчихсан барилга байгууламж байна. Ингээд ер нь хөдөө орон нутагт бол ийм барилга байгууламж, хөрөнгө оруулалтууд бол гацчихсан юм бол зөндөө л байна.

Тэгээд хэлэлцэж байгаа асуудалд асуулт асууж, хариулт авч дууслаа. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын дэд хороонд хүргүүлэх ёстой байгаа. Манайхаас төсөвт хэн байгаа билээ. Батиугар гишүүн танилцуулна. Батиугар гишүүн танилцуулъя. Хуралдаанд оролцсон ажлын хэсгийнхэнд баярлалаа.

16.11 цаг.

**2 дахь асуудалдаа орно. Боловсролын ерөнхий хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.**

2 дугаар хэлэлцэх асуудалд ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Ганболдын Ганбаяр Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын ерөнхий Гегазрын дарга, Жадамбын Мягмар Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга, Хөөжөөгийн Тамир Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон Мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Арьяагийн Цолмон Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсрол бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Чимэдрэгзэнгийн Баярмаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч, Жамцын Нарантуяа Боловсрол, шинжлэх

ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, Авирмэдийн Халиунаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга, Дарьсүхбаатарын Билгүүдэй Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын орон тооны бус зөвлөх, Ухнаагийн Туяа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч, Төмөрпүрэвийн Намнан Шинжлэх Ухаан, Технологийн их сургуулийн захирал, Шажинбатын Ариунаа Шинжлэх Ухаан Академийн Философийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор, Эрдэнийн Чойсүрэн Монгол Улсын Боловсролын Их сургуулийн багш, Заамбалын Цогтгэрэл Монголын боловсрол шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Наранцэцэгийн Номин Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн, Алтангэрэлийн Цэнгэл Хувийн цэцэрлэгүүдийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн, Дондогдуламын Тунгалаг “Бүх нийтийн боловсролын төлөө иргэний нийгмийн үндэсний эвсэл”-ийн ерөнхий зохицуулагч. Ийм бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хэлэлцэх асуудалд ажлын хэсэг оролцож байна.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Дамдинням танилцуулна.

**Г.Дамдинням:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Дээд боловсролын тухай хуулийн төслийн анхдугаар хэлэлцүүлэг Улсын Их Хурлын чуулганаар орж, 35 зарчмын зөрүүтэй санал хураагдаж дууссан. Энд одоо бид нар 1 зарчмын зөрүүтэй санал 3-ны хоёрдож солих шаардлагатай болчихоод байгаа. Найруулгын хувьд зохицуулалцах шаардлага гарч байгаа. Юу вэ гэхээр Төрийн өмчийн их дээд сургуулиудын аж ахуйн удирдлагыг эрдмийн удирдлагаас салгах нэгдсэн

зохион байгуулалтыг хийх заалт 23.3-д орсон байсан нь сургууль тус бүр дээр байхаараа уншигдаад хууль дээрээ заагдчих гээд байгаа учраас боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээрээ төвлөрсөн нэг ийм хөрөнгийн удирдлагын нэгж байхаар зохион байгуулалтыг хийе гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал орж ирэх юм.

Тэгээд энийг та бүхэн дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Дэгийн тухай хуулийн 42.1.3-д заасны дагуу танилцуулгатай холбоотойгоор асуулт асуух гишүүн байна уу. Дээд боловсрол явж байна. Алга байна. ажлын хэсгээс Дэгийн тухай хуулийн 42.2.3-д зааснаар дахин санал хураалгах шаардлагатай гэж үзэж 1 зарчмын зөрүүтэй санал гаргасан байгаа.

Ажлын хэсгийн саналаар санал хураалт явуулах байгаа. Ингээд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжиж байж энэ санал хураалт болсонд тооцогдох ёстой. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дэх заалтын “зэрэг” гэсний дараа “цол” гэж нэмж, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөл доор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх харьяа нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-д заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт 3-ны 2-оор энэ санал дэмжигдэх ёстой. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ. Ингээд байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжсэн тул ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар дахин санал хураалт явуулах ийм дэгтэй. Санал хураалт явуулъя. Санал хураалтыг танилцуулсан. Энэ санал 80 хувиар дэмжигдлээ.

Боловсролын ерөнхий хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны танилцуулга унших гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Дамдиннямьг томиллоо.

16.18 цаг.

**3 дугаар асуудал руугаа оръё. Дараагийн хэлэлцэх асуудал Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэж эхлэх ёстой байгаа.**

Байнгын хорооны хуралдаанд ирсэн ажлын хэсэг түрүүчийнх хэвээрээ

байгаа. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Дамдинням танилцуулна аа.

**Г.Дамдинням:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан билээ.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгээр Байнгын хорооноос дэмжсэн нийт 27 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцүүлж, улмаар 9 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өгсөн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу Ажлын хэсгийн зүгээс дээрх 9 зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг гүйцээн боловсруулан тус Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэгт санал хураалгахаар та бүхэнд танилцуулж байна.

2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Зөвшөөрлийн тухай хуулийн 9.6 дугаар зүйлд заасан шилжилтийн үеийн

зохицуулалтын дагуу Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбартай холбоотой зөвшөөрлийн харилцааг зохицуулах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн талаар Улсын Их Хурлын чуулгын нэгдсэн хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Дэгийн тухай хуулийн 42.1.3-д заасны дагуу танилцуулгатай холбоотойгоор асуух асуулттай гишүүд байна уу. Алга байна. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу Улсын Их Хурлын даргаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн 9 зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулна. мөн ажлын хэсгээс чуулганы нэгдсэн хуралдаанаар зарчмын зөрүүтэй саналуудыг дэмжсэнтэй холбогдуулан Дэгийн тухай хуулийн 44.5-д заасны дагуу “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхээр санал гаргасан байна. Төслийг гишүүдэд тараасан байна. Ингээд гүйцээн болгох гүйцээн боловсруулах 9 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулна. Саналын томъёоллыг унишиж танилцуулъя.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.3” гэснийг, 6.14 дэх хэсгийн “тусгай” гэснийг тус тус төслөөс хасаж, 6.2 дахь хэсгийн “бие даан ажил” гэснийг “хувиараа” гэж /цаашид тохиолдол бүрд/, 6.5 дахь хэсгийг “хэмжих ба багц цагийг дараагийн түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ” гэснийг “тооцох бөгөөд дараагийн боловсролын түвшинд дүйцүүлнэ” гэж, 6.6 дахь хэсгийн “багц цаг” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг” гэж, 6.8 дахь хэсгийн “ажил олгогчийн” гэснийг “түншлэлийн” гэж өөрчилж, 6.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөл доор дурдсан агуулгатай 6.15 дахь хэсэг нэмэх:

“6.11.Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.15.Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

Санал гаргасан ажлын хэсэг Санал хураалт. Санал 70 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Үнэлгээ, баталгаажуулалт” гэснийг “Чанарын баталгаажуулалт” гэж, 8.2 дахь хэсгийн “Хүний өмнөх мэдлэг, ур чадвар, чадамжийг” гэснийг “Эзэмшсэн мэдлэг, ур чадварыг” гэж өөрчилж, 8.1 дэх хэсгийн “суралцагч” гэсний өмнө “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дахь хэсгийг нэмэх:

“8.3.Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын

болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

8.4.Магадлан итгэмжлэлийг Боловсролын ерөнхий хуулийн 17.12-т заасан байгуулга мөн хуулийн 30.1.12-т заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ.

8.6.Боловсролын ерөнхий хуулийн 29.1.8-д заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 40.7-д заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 80 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “63.1, 63.2, 63.3 дахь заалтад” гэснийг “63 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилж, төслөөс 11.6, 11.7 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

4.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1 Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоонд Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д зааснаас гадна хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүрдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1 Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоонд Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д зааснаас гадна хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүрдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 80 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 22 дугаар зүйлийн гарчиг, 22.1 дэх хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/” гэж, 22.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хэсгийн “бүрдэнэ” гэснийг “бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна” гэж, 22.3, 22.5 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 22.6 дахь хэсгийн “Засгийн газарт” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-д заасан үндэсний зөвлөлд” гэж, төслийн 22.9.5 дахь заалтын “эдийн засгийн” гэснийг “эрэлттэй болон” гэж өөрчилж, мөн зүйлийн 22.8 дахь хэсгийг төслөөс хасаж, 22.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Зөвлөлийн даргыг мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүний олонхын саналаар томилно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

Дамдинням гишүүн ажлын хэсгийн ахлагч.

**Г.Дамдинням:** 6 дугаар санал дээр Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, өмнө 2 дугаар асуудал дээр бид нар Зөвшөөрлийн хуультай холбоотой асуудлыг шийдчихсэн учраас зарчмын зөрүүтэй саналын хамгийн сүүлд байгаа 23.1.9 дэх заалтыг хасах гэдэг хэсгийг

авч үлдмээр байна. 23.1.9 гэдгийг уншихгүйгээр та саналаа хураалгачихвал болох гээд байна дарга аа.

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүний саяын хэлснээр төслийн 23 дугаар зүйлийн санал хураалтаар хураалгах ёстой. Хураалгаад дотор нь хасалт хийсэн юм байна.

6.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтын “их сургууль, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, 23.1.4, 23.1.7 дахь заалтын “тусгай” гэснийг, 23.1.8 дахь заалтын “энгийн” гэснийг хасах. Манайхан материал дээрээ байгаа заалтыг харж байна уу. Ингэж хасаж уншаад санал хураалгахаар байгаа. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ санал 80 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа “Боловсролын эрхийн хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 24.1.7, 24.1.8, 24.1.9 дэх заалт, 24.2 дахь хэсэг нэмж, төслөөс 24.1.4, 24.1.5 дахь заалтыг хасах:

“24.1.7.багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг түншлэгч талуудтай хамтран зохион байгуулах;

24.1.8.багш, ажилтны мэргэжлийн зэрэг олгох ахиулах, сунгах;

24.1.9.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирлыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх.

24.2.Энэ хуулийн 24.1.7-д заасан чиг үүргийг Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” Санал

гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 80 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчилж, төсөлд 26.5.3, 26.5.4, 26.5.5, 26.5.6 дахь заалт, 26.7 дахь хэсэг нэмэх:

“26.4.Удирдах зөвлөл нь нийт арван нэгэн гишүүнтэй байх бөгөөд Төрийн захиргааны төв байгууллагаас гурав, нутгийн захиргааны байгууллагаас гурав, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх нэг, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх гурав, суралцагчийн нэг төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5.3.мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг батлах, үр дүн, чанар, гүйцэтгэлд хяналт тавих;

26.5.4.төсвийн хязгаарт нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар цалингийн санг тогтоох;

26.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг энэ хуулийн 23.1.10-т заасан журмын дагуу сонгон шалгаруулж томилох, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.5.6.боловсролын сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх;

26.7.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” Санал гаргасан ажлын хэсэг.



Санал хураалт. Энэ санал 80 хувиар дэмжигдлээ.

Саяын хураалгасан 26 дугаар зүйл дээр ажлын хэсгийн ахлагч санал гаргах гэж байна. Тэгэхээр түрүүчийн санал хураалтыг цуцалъя. Ажлын хэсгийн ахлагч Дамдинням.

**Г.Дамдинням:** Дарга аа, сая техникийн л юм болчихлоо. 8 дугаар санал хураалтыг ажлын хэсгээс татаж авах саналтай байгаа юм шүү. Татаж авах саналтай байгаа юм. Тэгэхээр дэгийнхээ хуулиар хэдүүлээ 1 санал дээр 3 удаа санал хураах ёстой учраас саяынх дэмжсэнээрээ явчхаж байгаа байх. Тэгэхээр 2 удаа санал хураалгаад эсрэг санал өгчихвөл болчих гээд байна. Дэгийн хууль зөрчихгүй юм шиг байна. Ийм маягаар. Энэ дээр дахин санал хураалгаж өгөөч. 8 дугаар санал дээр. Тэгээд саналаа татаж байна. Энэ дээр дахин санал хураалгаж өгөөч. Нэгэнт хураачихсан учраас дахиж нэмж хураахаас өөр аргагүй л болно л доо. Тэгээд тэрийгээ Байнгын хорооны зөвлөхүүд даргад хэлчих. Ямар ч байсан 8 дугаар саналыг бид нар дэмжихгүй байгаа юм. Ажлын хэсэг дээрээс.

**Г.Мөнхцэцэг:** Саяын ажлын хэсгийн ахлагчийн гаргасан горимын саналаар энэ санал хураалтыг цуцалъя гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт дэмжинэ шүү дээ. Ажлын иц хэсгийн ахлагчийн гаргасан саналаар санал хураалтыг цуцалъя гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулсан. 60 хувиар дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулах ёстой. 8 дугаар саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ 2 дахь санал хураалт. Санал 100 хувиар дэмжигдсэнгүй. Ингээд хаслаа.

9.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг “мэргэжлийн

сургалтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө” гэж, 29.4.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.3.3, 29.3.4 дэх заалт нэмэх:

“29.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын тодорхой хувь;

29.3.4.энэ хуулийн 19.4-д заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт 60 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн хэрэгжүүлэх арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Асуух асуултыг гишүүн байна уу. Алга байна. Санал гаргах гишүүн байна уу. Алга байна. Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Дамдинням горимын санал гаргана.

**Г.Дамдинням:** Байнгын хорооны дарга аа, Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 39.22-оор хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэсэн дэгийн хуулийн дагуу 2 хэлэлцүүлгийг нэгтгээд явуулах горимын санал гаргаж байна.

**Г.Мөнхцэцэг:** Ажлын хэсгийн ахлагч Дамдиннямыг гаргасан горимын саналаар санал хураалт явуулах дэгтэй

байгаа. Ингээд санал хураалт. Дэмжинэ дэмжинэ гэж санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ. Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай хуулийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.22-оор хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэсэн хуулийн заалтыг үндэслэж анхны болон эцсийн хэлэлцүүлгийг хамтад нь явуулах горимын санал гаргаж байна.

**Г.Мөнхцэцэг:** Ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Адьяасүрэн гишүүн санал гаргах уу.

**А.Адьяасүрэн:** Байнгын хорооны дарга аа, горимын санал оруулах гэсэн юм. Сая төхөөрөмж ажилласангүй,

тэгээд санал хураалтыг дахиж явуулж өгөөч.

**Г.Мөнхцэцэг:** Адьяасүрэн гишүүний гаргасан саналын томъёоллоор дахин санал хураалт явуулах саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

Дахин санал хураалт. Түрүүчийн Дамдинням гишүүний гаргасан горимын саналаар дахин санал хураалт явуулна. Санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийн зүйл бүрээр нь хэлэлцэнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна. Дамдинням гишүүн горимын санал гаргана.

**Г.Дамдинням:** Байнгын хорооны дарга аа, Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.22-ыг үндэслээд хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэсэн заалтыг үндэслэн анхны болон эцсийн хэлэлцүүлгийг хамтад нь явуулах горимын санал гаргаж байна.

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт

явуулъя. Санал хураалт. Энэ санал 60 хувиар дэмжигдлээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна алга байна.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Алга байна.

3 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу. Дамдинням гишүүн энэ дээр бас горимын санал гаргах байгаа. Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Дарга аа, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 39.22-ыг үндэслээд хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно гэснийг үндэслэж анхны бөгөөд эцсийн хэлэлцүүлгийг хамтад нь явуулах горимын санал гаргаж байна.

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх тухай асуудлыг хэлэлцэж дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанд байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Дамдинням танилцуулна.

Өнөөдрийн байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө.

Гишүүд түр байж байгаарай. Ажлын хэсгийн ахлагчаас. Гэхдээ энэ хуралдааны хэлэлцэх асуудалд ороогүй байгаа. Ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн нэг танилцуулга хийе Боловсролын ерөнхий хуулиар.

**Г.Дамдинням:** Боловсролын ерөнхий хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар анхдугаар хэлэлцүүлэг амжилттай явж өнгөрсөн. Хуралдааны чуулганы хэлэлцүүлгийн явцад 2 зарчмын зөрүүтэй санал үлдээд, бусад саналууд дууссан байгаа. Эцсийн хэлэлцүүлэг дээр. Тэгээд Улсын Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу зүйл заалтаар хэлэлцэгдэх зайлигүй шаардлагатай болсон учраас манай Боловсролын ерөнхий хууль үндсэндээ 5 зарчмын зөрүүтэй санал үлдчихсэн байгаа. 5 зарчмын зөрүүтэй санал болж хувирсан. Өөрөөр хэлбэл 1 зарчмын зөрөөтэй санал багцлагдаж орсон гэсэн техникийн асуудал үүссэн учраас энд бид нар тэр зүйл заалтаар нь явах дэгийн тухай хуулиа дагаад 4 зарчмын зөрүүтэй санал болгосон. Санал болгож оруулж байгаа. 5 дугаарт нь нөгөө хэлтэй холбоотой асуудал орж ирнэ. Ингээд англи хэлтэй холбоотой асуудал орж ирж байгаа. Ингээд 5 зарчмын зөрүүтэй саналаар манай Боловсролын ерөнхий хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал эцсийн хэлэлцүүлэг чуулганы хуралдаанд орж дуусна гэсэн мэдээллийг бас гишүүддээ өгье. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүнд баярлалаа. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө. Хуралдаанд амжилттай оролцсон гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

16.50 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

Э.СУВД-ЭРДЭНЭ